**БЭЙКЕР ТИЛЛИ**
**ДАЛАЙВАН АУДИТ**
[illegible]

Монгол Улс, Улаанбаатар хот-16060
[illegible]
Утас: [illegible]
Факс: +976-[illegible]
Э-Шуудан: [illegible]
Веб хуудас: [illegible]

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**"ДАРХАН НЭХИЙ" ХК-ИЙН**
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД**

### Санал дүгнэлт

Бид 2020 оны 12 дугаар сарын 31 өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Дархан Нэхий" ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр "Дархан Нэхий" ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн гаргасан журам зааврын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг "МНБ-ын ёс зүйн дүрэм"-г мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

### Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд анхаарал хандуулахуйц аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрдэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажуулалтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажиллаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй болно.

**Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага**

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

**Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гүйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
(үргэлжлэл)

- ✓ Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох толруулгын хэсэгт бид анхааралаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох толруулгал хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон толруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мөрдөгдсөн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

**Хэрэглээний хязгаарлалт**

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн ба тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

УЛААНБААТАР ХОТ
ДАЛАЙВАН АУДИТ
ХХК

2021 ОНЫ 04 ДҮГЭЭР
САРЫН 22-НИЙ ӨДӨР

## САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

2020 оны 12-р сарын 31-ний өдөр

(мян.төг)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| **Хөрөнгө** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 458,005.70 | 582,727.50 |
| Дансны авлага | 6,254,458.80 | 5,464,813.60 |
| Татвар, НДШ-ийн авлага | 192,103.60 | 114,605.10 |
| Бусад авлага | 134,037.80 | |
| Бараа материал | 14,886,578.60 | 15,111,964.80 |
| Урьдчилж төлсөн зардал | 310,034.80 | 612,879.30 |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | 641,784.30 | |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө | 3,354,133.80 | 2,020,302.40 |
| ***Эргэлтийн хөрөнгийн дүн*** | **26,231,137.40** | **23,907,292.70** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | 27,968,307.40 | 34,317,813.00 |
| Биет бус хөрөнгө | 45,552.80 | 15,498.20 |
| Биологийн хөрөнгө | | |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 1,000.00 | 1,000.00 |
| Дуусаагүй барилга | 9,031,468.00 | 2,393,976.10 |
| *Эргэлтийн бус хөрөнгийн дүн* | 37,046,328.20 | 36,728,287.30 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **63,277,465.60** | **60,635,580.00** |
| **Өр төлбөр ба эздийн өмч** | | |
| **Өр төлбөр** | | |
| Дансны өглөг | 1,311,720.50 | 1,433,153.00 |
| Цалингийн өглөг | 145,350.50 | 9,009.00 |
| Татварын өр | 2,028,053.90 | 2,592,658.20 |
| НДШ-ийн өглөг | 434,025.90 | 108,171.10 |
| Богино хугацаат зээл | 1,199,040.80 | 607,997.60 |
| Бусад богино хугацаат өр | 31,959.30 | |
| Ногдол ашгийн өглөг | | 232,150.60 |
| Урьдчилж орсон орлого | 3,793,916.10 | 2,614,471.90 |
| **Урт хугацаат өглөг** | **10,295,048.70** | **7,940,324.60** |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **19,239,115.70** | **15,537,936.00** |
| **Эздийн өмч** | | |
| Өмч-Хувийн | 3,753,574.90 | 3,753,574.90 |
| Халаасны хувьцаа | (16,428.50) | (16,428.50) |
| Нэмэгдэж төлөгдсөн капитал | (106,648.60) | (106,648.60) |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 19,334,524.60 | 19,334,524.60 |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 4,319,122.60 | 7,353,587.20 |
| Хуримтлагдсан ашиг | 13,075,920.60 | 11,100,750.10 |
| Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох | 3,678,284.30 | 3,678,284.30 |
| **Эздийн өмчийн дүн** | **44,038,349.90** | **45,097,644.00** |
| **Өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | **63,277,465.60** | **60,635,580.00** |



BAKERTILLY
"DALAIVAN-AUDIT" CO.,LTD
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
&APPRAISAL

# ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2020 оны 12-р сарын 31-ний өдөр

(мян.төг)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| **Борлуулалтын орлого (цэвэр)** | **20,254,732.70** | **16,886,245.10** |
| Борлуулалтын өртөг | 13,776,299.30 | 10,718,188.30 |
| **Нийт ашиг** | **6,478,433.40** | **6,168,056.80** |
| Түрээсийн орлого | 669,037.80 | 623,819.60 |
| Хүүний орлого | 384,451.60 | 331,673.60 |
| Ногдол ашгийн орлого | | |
| Эрхийн шимтгэлийн орлого | | |
| Бусад орлого | 294,989.50 | 235,952.50 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 4,918,464.70 | 3,841,926.00 |
| Борлуулалт маркетингийн зардал | 86,077.70 | 322,184.40 |
| Санхүүгийн зардал | | |
| Бусад зардал | 441,066.20 | 1,288,247.30 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | (10,073.10) | (8,169.70) |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 36,047.00 | |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | | |
| Бусад ашиг алдагдал | 206,522.20 | 42,767.60 |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | **2,613,799.80** | **1,941,742.70** |
| Орлогын татварын зардал | 286,166.40 | 255,815.70 |
| Татварын дараах ашиг (алдагдал) | 2,327,633.40 | 1,685,927.00 |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг | | |
| **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **2,327,633.40** | **1,685,927.00** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| Бусад олз (гарз) | | |
| Орлогын нийт дүн | | |
| Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | | |



BAKERTILLY
"DALAIVAN-AUDIT"CO.Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
APPRAISAL

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2020 оны 12-р сарын 31-ний өдөр

(мян.төг)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн орлого | **28,645,737.80** | **29,587,877.90** |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого | 22,860,320.80 | 16,941,241.60 |
| Эрхийн шимтгэлийн орлого | 4,722,417.40 | 158,112.50 |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгөн | | |
| Бусад орлого | 1,062,999.60 | 12,488,523.80 |
| ***Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн зардал*** | **28,511,375.70** | **28,874,354.10** |
| Ажиллагсад олгосон мөнгө | 3,664,088.00 | 2,212,661.40 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | 805,668.00 | 562,953.60 |
| Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө | 10,859,690.10 | 10,592,764.00 |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | 1,267,939.10 | 982,795.70 |
| Түлш, шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | 1,381,218.40 | 478,636.30 |
| Хүүний төлбөрт төлсөн | 2,025,176.20 | 1,588,350.00 |
| Татварын байгууллагад төлсөн мөнгө | 837,419.50 | 649,709.80 |
| Даатгалын төлбөрт төлсөн | | 10,651.10 |
| Бусад зардал | 7,670,176.40 | 11,795,832.20 |
| *Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ* | **134,362.10** | **713,523.80** |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого | 57,548.90 | 791,036.50 |
| Биет бус хөрөнгө борлуулсны орлого | | |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө | (4,516,033.70) | (791,211.60) |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | | |
| Хүлээн авсан хүүний орлого | 384,451.50 | 484,017.80 |
| Бусад | | |
| *Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ* | **(4,074,033.30)** | **483,842.70** |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 7,641,800.00 | 4,697,138.60 |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | (4,385,022.50) | (5,754,561.30) |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | | |
| Авлагын цугларалт | | |
| Төрөл бүрийн хандив | | |
| Хөрөнгө борлуулсаны орлого | | (15,222.00) |
| Бусад | | |
| *Санхүүгийн цэвэр мөнгөнгүйлгээ* | **3,256,777.50** | **(1,072,644.70)** |
| Валютын ханшийн зөрүү | | |
| **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(682,893.70)** | **124,721.80** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,140,899.40 | 458,005.70 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 458,005.70 | 582,727.50 |



BAKERTILLY
"DALAIVAN AUDIT" CO.,Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING

# ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙНТАЙЛАН

2020 оны 12-р сарын 31-ний өдөр

(мян.төг)

| Үзүүлэлт | Өмч | Халаасны хувьцаа | Нэмэгдэж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Хяналтын бус хувь оролцоо | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2018 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл | 5,259,944.00 | (16,428.50) | (106,648.60) | 19,334,524.60 | 3,702,920.20 | 15,242,394.40 | 1,051,075.30 | 44,467,781.40 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | (1,506,369.10) | | | | 616,202.30 | (2,166,473.80) | 299,575.60 | (2,757,065.00) |
| Залруулсан үлдэгдэл | | | | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | | | | | | - |
| Бусад орлого | | | | | | | 2,327,633.40 | 2,327,633.40 |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | | | - |
| | | | | | | | | - |
| 2019 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл | 3,753,574.90 | (16,428.50) | (106,648.60) | 19,334,524.60 | 4,319,122.50 | 13,075,920.60 | 3,678,284.30 | 44,038,349.80 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | | | - |
| Залруулсан үлдэгдэл | | | | | | | | |
| Бусад орлого | | | | | | | | - |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | | | | | | - |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | 1,685,927.00 | | 1,685,927.00 |
| Зарласан ногдол ашиг | | | | | 3,034,464.70 | (3,428,946.90) | | (394,482.20) |
| | | | | | | (232,150.60) | | (232,150.60) |
| 2020 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл | 3,753,574.90 | (16,428.50) | (106,648.60) | 19,334,524.60 | 7,353,587.20 | 11,100,750.10 | 3,678,284.30 | 45,097,644.00 |

BAKERTILLY
"DALAIVAN AUDIT" CO.,LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING & APPRAISAL